



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ  
УУРХАЙН ЯАМ



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# Эрдэнэс ТТ ХК-ийн засаглалын үнэлгээ

Улаанбаатар хот  
2014 он

# Эрдэнэс ТТ ХК-ийн засаглалын үнэлгээ

---

Судлаач: Д.БАЙЛЫХҮҮ

© Нээлттэй Нийгэм Форум, 2014

Энэхүү судалгааг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48

DDC  
657.3  
Б-188

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

ISBN 978-9973-0-424-7

# 1


## Үнэлгээний аргачлалын тойм

Энэхүү үнэлгээг хийхдээ компанийн засаглалын гол бүрэлдэхүүн хэсэг болох дор дурдсан есөн элементийг үнэлгээний үзүүлэлт болгон авч тэдгээр үзүүлэлтийн хүрээнд тухайн компани зайлшгүй баримтлах ёстой сайн засаглалын нийтлэг зарчим болон Монгол Улсын Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг асуулгын аргаар үнэлж гаргалаа. Ингэхдээ асуулга бүрийн хүрээнд хийгдэх ажлын хэрэгжилтийг 0-5 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргалаа. Үүнд:

### 1. Үнэлгээг тодорхойлох үзүүлэлтүүд

- Хувьцаа эзэмшигч түүний эрхийн хамгаалалт
- ХЭ-ийн хурал (ХЭХ)
- Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
- Гүйцэтгэх удирдлага (ГУ)
- Мэдээллийн ил тод, нээлттэй байдал
- Чухал хэлцлүүд
- Ногдол ашиг
- Дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн актууд
- Хяналтын тогтолцоо эдгээр болно.

### 2. Үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг тодорхойлох асуулгуудад өгөх үнэлгээ:



Үнэлгээний дэлгэрэнгүй аргачлалыг энэхүү тайлангийн төгсгөлд Хавсралт 2-т үзүүллээ.

## 2

## Үнэлгээний ерөнхий дүн

Компанийн засаглалын ерөнхий үнэлгээг үзүүлсэн Хүснэгт 1-ээс харахад тус компанийн засаглалын түвшин оноогоор тооцоход 5 авахаас 1.0 оноо, хувиар тооцвол 100 хувь байхаас 24.2 хувийн үнэлгээ авсан байна. Үүнийг Хавсралт 2-т үзүүлсэн аргачлалын дагуу үзүүлэлтүүдийг ач холбогдлоор нь жигнэн тооцоолж үзэхэд 20.6 хувьтай гарчээ. Энэ нь ОУСК-аас 2008 онд гаргасан “Компанийн засаглалын гарын авлага”-д дурьдсан компанийн засаглалын түвшингээр авч үзэхэд тус компани засаглалын чиглэлээр гарсан хуулийн заалтыг хагас дутуу биелүүлдэг, түүнээсээ болоод зарим тохиолдолд дампуурах магадлал өндөр байна гэж үзэхээр үнэлгээ гарч байна.

Хүснэгт 1. Эрдэнэс ТТ ХК-ын засаглалын нэгдсэн үнэлгээний дүн

№	Үнэлгээний үзүүлэлтүүд	Үнэлгээний оноо	Үнэлгээ /хувиар/	Ач холбогдлын коэффициент	Жигнэсэн дундаж үнэлгээ
1	Хувьцаа эзэмшигч түүний эрхийн хамгаалалт	0.8	16.0	5.0	80
2	ХЭ-ийн хурал	1.0	20.0	7.5	150
3	Төлөөлөн удирдах зөвлөл	1.7	34.0	20.0	680
4	Гүйцэтгэх удирдлага	0.8	16.0	7.5	120
5	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0.3	6.0	25.0	150
6	Чухал хэлцлүүд	1.0	20.0	25.0	500
7	Ногдол ашиг	0	0	2.5	0
8	Дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн актууд	2.1	42.0	5.0	210
9	Хяналтын тогтолцоо	3.1	62.0	2.5	155
10	Дундаж дүн	1.2	24.4	-	20.6

Компанийн авсан үнэлгээг төрийн өмчит уул уурхайн компаниудын дундажтай харьцуулахад тус компани нь засаглалын үнэлгээгээрээ салбартаа 5 дугаарт орж байна. Төрийн өмчит уул уурхайн компанийн дундаж үзүүлэлтийг тус компанийн түвшинтэй харьцуулан Зураг 1-д үзүүлэв.

Зураг 1. Эрдэнэс ТТ ХК-ийн засаглалын түвшинг төрийн өмчит уул уурхайн компаниудын дундаж үзүүлэлттэй харьцуулсан байдал



Компанийн ерөнхий үнэлгээ нь төдийлөн сайн биш байгаа боловч зарим үзүүлэлт тухайлбал, хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэх чухал нөхцлүүдийн нэг болсон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг Компанийн тухай хуульд заасны дагуу энэ ажлыг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж байгаа учраас ХЭ-ийн бүртгэл, түүний хөтлөлт, бүртгэлийн агуулга үзүүлэлтээр 5 оноо авсан байна. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх талаар компанийн зүгээс хүлээсэн үүргээ сайн хэрэгжүүлж байгаа жишээ юм. Үүнээс гадна тус компанийн Гүйцэтгэх захирал болон түүний удирдлагад ажилладаг ажилтнууд ТУЗ-ийн гишүүн биш байгаа нь ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагатай ажиллахад аливаа сонирхлын зөрчил үүсгэхгүй болгосон учир үүнтэй холбоотой асуулгуудад 5 оноо авсан байна. Үүнийг Зураг 2-т үзүүлэв.

Зураг 2. Эрдэнэс ТТ ХК-ийн засаглалын үнэлгээнд сайн үнэлгээ буюу 5 оноо авсан асуулгууд



Үүнээс гадна үнэлгээний үзүүлэлтийн нийт 131 асуулгаас 68 буюу 51.9 хувьд нь “0” үнэлгээ авсан нь эдгээр үзүүлэлтийн хувьд тус компани дээр тодорхой зүйл хийгдэхгүй байгааг харуулж байна. Энэ нь тус компанийн засаглалын түвшин доогуур гарах гол шалтгаан болсон. Нийт үнэлгээнд “0” үнэлгээ авсан асуулгуудын эзлэх хэмжээг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Эрдэнэс ТТ ХК-ийн засаглалын үзүүлэлтүүдийн нийт дүнд  
“0” оноо авсан асуулгын тоо, хэмжээ

№	Үнэлгээний үзүүлэлтүүд	Нийт асуулгын тоо	“0” оноо авсан асуулгын тоо	“0” оноо авсан асуулга /хувиар/
1	Хувьцаа эзэмшигч түүний эрхийн хамгаалалт	16	10	62.5
2	ХЭ-ийн хурал	19	10	55.6
3	Төлөөлөн удирдах зөвлөл	48	20	41.6
4	Гүйцэтгэх удирдлага	10	7	70
5	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	8	80
6	Чухал хэлцлүүд	9	7	77.7
7	Ногдол ашиг	5	4	80
8	Дүрэм болон засаглалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулж буй бусад эрхийн актууд	6	1	16.6
9	Хяналтын тогтолцоо	8	1	12.5
10	Дүн	131	68	51.9

Дээрх хүснэгтээс харахад компанийн засаглалын түвшинг доош татаж буй гол үзүүлэлт нь мэдээллийн ил тод нээлттэй байдал, чухал хэлцэл, ногдол ашиг, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын томилгоо, ажил үүргийн тайлагналт зэрэгтэй холбоотой асуудлууд байгаа бөгөөд эдгээрийн хүрээнд хийгдэх ёстой ажлын нийт 73 асуулгаас 43 буюу 60 гаруй хувьд нь тодорхой зүйл тус компанид хийгдэлгүй орхигджээ. Энэхүү орхигдсон ажлууд нь нийт “0” үнэлгээ авсан үзүүлэлтийн 80 шахам хувийг эзэлж байна. Иймд цаашид эдгээр асуудлын хүрээнд тус компани их зүйл хийх хэрэгтэйг харуулж байна. Нийт “0” үнэлгээ авсан үзүүлэлтийн хүрээнд хийх ажлын талаар өгөх зөвлөмжийг үнэлгээ өгсөн үзүүлэлт бүрээр бүлэглэн дор дурдсан байдлаар үзүүлэв.

# 3

## Эрдэнэс ТТ ХК-ийн засаглалын түвшинг сайжруулах-Зөвлөмж

Тус компанийн засаглалын өнөөгийн түвшинг сайжруулах талаар хийх ажлын Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүмүүст ойлгомжтой байх үүднээс үнэлгээ хийсэн үзүүлэлтүүдээр бүлэглэн доорх байдлаар үзүүлэв. Үүнд:

### 3.1 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хувьцаа эзэмшигч нь дараах нийтлэг эрхтэй

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх
3. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг авах
4. Компани татан буугдах үед төлбөр, хураамжийг төлөөд үлдсэн эд хөрөнгөөс өөрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээтэй хувь тэнцүүлэн авах
5. Компани үнэт цаас гаргах тохиолдолд өөрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээтэй хувь тэнцүүлэн уг үнэт цаасаас тэргүүн ээлжид худалдан авах
6. Компанийн нэг буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах
7. Компани нийлэх, нэгтгэх, өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдах, дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн өөрчлөлт орох тохиолдолд эсрэг саналтай байсан болон санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах
8. Нэг этгээд компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас, эсвэл 75 хувийн хувьцаа эзэмшигчээс шаардах



№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Хувьцаа эзэмшигчид (ХЭ)-ийн бүртгэл хөтлөх этгээдтэй гэрээ байгуулсан эсэх	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр өөрийн ХЭ-ийн бүртгэлийг хөтлүүлэх замаар ХЭ-ийнхээ эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах ёстой. Иймд ойрын хугацаанд ҮЦТТХТ-тэй гэрээ байгуулах замаар ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг хангах	ГЗ, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (НБД)
2	ХЭ-ийн ээлжит хурлын үед ХЭ-ийн авах ёстой мэдээллийг бүрэн хүргэдэг эсэх	1. Компанийн тухай хуулийн 65.6 –д заасан мэдээллийг холбогдох этгээдүүд бэлтгэн компанийхаа вэб дээр тавихаас гадна хурлын зар хүргэх журмын дагуу ХЭ-д хүргэдэг болгох, ингэснээрээ ХЭ-д ядахдаа жилд 1 удаа компанийн талаар тодорхой мэдээлэл авдаг болно. 2. ТУЗ нь ХЭ-ийн ээлжит хурлыг хуралдүүлэх шийдвэртээ дээрх мэдээллийг бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах этгээдийг зааж үүрэг болгосон заалт оруулах	ХЭ-ийн ээлжит хурал хуралдахын өмнө ТУЗ-ийн НБД холбогдох ажилтнуудаар гаргуулан ХЭ-д хүргүүлэх ажлыг зохион байгуулдаг болох
3	ХЭ-д компанийн санхүүгийн талаарх мэдээлэл авах бололцоог хангасан байдал	Улирал, жилийн санхүүгийн тайланг өөрийн вэб дээр байнга тавьдаг журамтай болох	ТУЗ-ийн НБД холбогдох ажилтнаас авч тавьдаг болох
4	ХЭ компанийн үйл ажиллагаа болон компани дээр болж буй томоохон үйл явдлын талаар байнгын мэдээлэл авах бололцоог хангасан байдал	Томоохон үйл явдал гэж юуг хэлэхийг компанийхаа онцлогтой холбогдуулан МБББ-д тодорхойлж түүнийгээ вэб дээр заавал мэдээлэхээс гадна шаардлагатай бол мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг болох	Мэдээллийн асуудал хариуцсан ажилтан хэрэв байхгүй бол ТУЗ-ийн НБД, аль ч тохиолдолд НБД энэ ажилд хяналт тавина
5	Төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг төрийг төлөөлөн эзэмшиж буй этгээдийн төлөөлөх хэмжээг тусгайлан тогтоож өгсөн эсэх	Компанийн дүрэмд Төрийн эзэмшиж буй хувьцааны эрхийг төрийн байгууллагуудын эрх хэмжээнд тохируулан хуваарилсан заалт оруулж түүний дагуу төрийн байгууллагууд компанитай харьцдаг болох	ТУЗ компанийн дүрэмд энэ талаар тодорхой заалт оруулах
6	ХЭ-ийн эдлэх эрхийг тусгайлан гаргаж нийтэд мэдээлэх	Олон жижиг ХЭ-тэй, цаашдаа IPO хийх хандлагатай компанийн хувьд ХЭ-ийн эрхийг хамгаалах тэдгээртэй хэрхэн харьцах талаар тусгайлсан бодлого гаргаж түүнийгээ эрх бүхий этгээдээр батлуулан хэрэгжүүлдэг болох	ТУЗ-ийн НБД
7	Жижиг ХЭ-ийн эрхийг хамгаалах хүрээнд тусгайлсан ажиллагаа байгаа эсэх		

8	Зарласан болон гаргасан хувьцааг бүртгэлд тусгасан байдал	Зарласан болон гаргасан хувьцааны тоо болон нэрлэсэн үнийн асуудлыг иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн, худалдсан хувьцааны үнэнд үндэслэн тооцоог гаргаж бүртгэлд зөв тусгах, үүнтэй холбогдуулан төрийн оруулсан хөрөнгө, төрөөс олгосон 6.0 тэрбум тн. нүүрс олборлох тусгай зөвшөөрлийн үнэ цэнэ зэргийг тооцоолон бүртгэлдээ зөв тусгах, эдгээр асуудлыг цаашдаа IPO гаргах асуудалд саад болгохгүй байх үүднээс андрайтераар сонгон авсан компанийн зөвлөмжийг авч санал боловсруулан холбогдох этгээдэд оруулан шийдвэрлүүлэх.	ГЗ, ТУЗ
9	ХЭ-ийн оруулсан хөрөнгийг бүртгэлд тусгасан байдал		

### 3.2 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хувьцаа эзэмшигчдийн хурал нь нэг талаар компанийн эрх барих дээд байгууллага, нөгөө талаар хувьцаа эзэмшигчдээс компанийн эзэн гэдэг утгаараа компанийн үйл ажиллагаатай холбоотой хамгийн чухал асуудлыг хэлэлцэхэд оролцож саналаа өгөх замаар шийдвэрлэдэг удирдлагын чухал бүтэц учраас түүнийг зохих журмын дагуу нь хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийг ялгаварлахгүйгээр бүгд оролцох бололцоог хангах явдал нь компанийн зүгээс хийх чухал ажлын нэг. Гэтэл тус компани энэ асуудлаар 1 оноо, 19 үзүүлэлтээс 10-д нь “0” үнэлгээ авсан байна. Эдгээрийг сайжруулах талаар өгөх зөвлөмжийг доорх хүснэгтэд үзүүлэв.

#### Хувьцаа эзэмшигчдийн хурал

*ХЭХ нь хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр бөгөөд компанийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны гол чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг тул компанийн эрх барих дээд байгууллага нь болдог. Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тухайн хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ.*

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	ХЭХ хуралдуулах тусгайлсан журамтай эсэх	Хэт олон ХЭ-тэй онцлог байдалтайгаа уялдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон болон ээлжит бус хурлыг саналын хуудсаар санал авах замаар хийдэг байхаар тусгайлан журам боловсруулж түүнийгээ ТУЗ-ийн хурлаар батлуулан нийт ХЭ-дээ зарлан мэдээлж түүний учир шалтгааныг хэвлэл мэдээллээр дамжуулан нийтэд ойлгуулах ажлыг зориуд зохион байгуулах.	ТУЗ, ГЗ
2	Журамд зохих зүйлийг заасан эсэх		
3	Саналын хуудасны загвар хувьцаа эзэмшигчдээс саналаа өгөх боломжийг хангасан эсэх	Зөвлөмжийн төгсгөлд үзүүлсэн саналын хуудсын жишээг үндэслэн ТУЗ-өөс ХЭХ бүрийн хэлэлцэх асуудалд тохируулан ХЭ-ээс санал авах хуудсыг батлан гаргаж байх	ТУЗ
4	Тооллогын комиссын үйл ажиллагааг зохицуулсан журамтай эсэх	ХЭХ-аас зөв шийдвэр гаргахад ТК-ын үйл ажиллагаа маш чухал тул түүний үйл ажиллагааг зохицуулсан журамтай байх.	ТУЗ, ГЗ
5	Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргадаг эсэх	ХЭХ-д хэлэлцэх асуудлаар санал өгсөн ХЭ-ийг хуралд оролцсон гэж үздэг тул хэлэлцэх асуудал бүрээр хурлын ирцийг гаргадаг болох.	ТК

6	ТК нь хэлэлцэх асуудалд ирүүлсэн саналын талаар тогтоол гаргадаг эсэх	ТК тоолсон зүйл бүрээр тогтоол гаргаж ХЭХ-ын даргад ирүүлэн түүний дагуу ХЭХ шийдвэрээ гаргадаг байх	ТК, хурал даргалагч
7	Хурал даргалагч ба ТК-оос ХЭХ-ын талаар нэгдсэн тайлан гардаг эсэх, түүнийгээ мэдээлдэг байдал	ХЭХ-ын дараа хурлыг хэрхэн бэлтгэн зохион байгуулсан талаар товч тайлан гаргаж цахим хуудас дээрээ тавьдаг болох	-"
8	Хурлын зар хүргэх тусгай журамтай эсэх	Тус компанийн хувьд олон ХЭ-д ХЭХ-ын зарыг хэрхэн хүргэх асуудлыг тусгасан тусгай журам гаргах шаардлагатай бөгөөд түүнийхээ талаар нийтэд мэдээлэн ойлгуулах ажлыг тусгайлан зохион байгуулах.	ТУЗ, ГЗ
9	ХЭХ-аас гарах шийдвэр гаргалт	ХЭХ-аас гаргасан шийдвэрийг заавал нийтэд мэдээлж өөрийн цахим хуудасдаа тусгайлан тавьдаг болох	ТУЗ-ийн НБД
10	Хурлаас гаргасан шийдвэрийг нийтэд мэдээлдэг эсэх	ХЭХ-ын шийдвэрийг нууцад хамаарахгүй тохиолдолд заавал мэдээлж энэ нь хурал тус бүрээр харагдаж байхаар цахим хуудасдаа хийх	ТУЗ-ийн дарга, НБД
11	ХЭХ хуралдуулах талаар ХЭ-ээс ирүүлсэн хүсэлт шаардлагыг хэрэгжүүлдэг эсэх	Энэ бол ХЭ-ийн нэг чухал эрх тул тус компани олон хувьцаа эзэмшигчтэй онцлогтойгоо уялдуулан ХЭ-ээс ХЭХ-ыг хуралдуулан тодорхой асуудал хэлэлцүүлэх санал гаргах бололцоог хангах үүднээс Компанийн тухай хуулийн энэ талаарх заалтыг үндэслэн тусгайлсан журамтай байх нь зүйтэй.	ТУЗ
12	ХЭХ-д Төрийн мэдлийн хувьцааг төлөөлөн оролцох этгээдийг томилох этгээд нь тодорхой эсэх	Тус компанийн ХЭХ-д толгой компанийг төлөөлөн оролцох этгээдийг томилох этгээдийг тодорхой болгох	ГЗ, ТУЗ-ийн НБД
12	Томилсон шийдвэр гардаг эсэх гардаг бол ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийг өгдөг эсэх	ХЭХ-д толгой компанийн төлөөлөгч ирэхдээ өөрийг нь хуралд орохоор томилсон томилгоо болон хурлаар хэлэлцэх асуудлаар өгөх саналын удирдамжтай ирдэг байх, үүнийгээ хурлын тооллогын комисст үзүүлэн хуралд оролцох, эсвэл эдгээрийгээ саналын хуудсын хамт компанид ирүүлэх замаар хуралд оролцох. Энэ талаар 2 компанийн дүрэмд тодорхой заалт оруулсан байх	-", ТК
14	ХЭХ-д төрийн төлөөлөл зохих журмын дагуу оролцдог эсэх		

### 3.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Тус компанийн ТУЗ-ийн ажиллагааны ерөнхий үнэлгээ нь 1.7 оноо буюу 34 хувь байгаа нь бусад компанийн дундаж үзүүлэлттэй адил байгаа юм. Мөн энэ бүлэгт хамаарах 48 асуулгын 20-д нь “0” оноо авчээ. Энэ дүнгээс харахад цаашид ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах зүйл нэлээдгүй байгаа нь харагдаж байна. Үүнтэй холбогдуулан хийх ажлын талаар өгөх зөвлөмжийг доорх хүснэгтэд үзүүлэв.

#### Төлөөлөн удирдах зөвлөл

*ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж ерөнхий удирдлагаар хангах үүрэг бүхий компанийн эрх барих байгууллага мөн.*

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Нэр дэвшүүлэх хороо (НДХ)-ны бүрэлдэхүүний ажиллагаа зохих журмын дагуу явагддаг эсэх	НДХ-г ТУЗ-ийн гишүүд, ГЗ-д ажиллах хүнд тавих шаардлагыг компанийхаа онцлогт тохируулан боловсруулж ТУЗ-өөр батлуулан тэдгээрт тохирох хүмүүсийг олж бэлтгэх, шаардлага гарсан тохиолдолд нэр дэвшүүлэхэд бэлэн байхаар ажлыг зохион байгуулах.	ТУЗ
2	ТУЗ-ийн гишүүдийн нэр дэвшүүлэлт зохих журмын дагуу явагдсан эсэх	Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн бүх гишүүдийг зөвхөн НДХ-ны дэвшүүлсэн хүнийг ХЭХ хэлэлцэн шийдвэрлэх ёстой. Иймд төр болон бусад этгээд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ зөвхөн НДХ-д ирүүлэх ба хороо тэдгээрийг зохих шаардлага хангасан эсэхийг хянан үзээд бололцоотой гэж үзвэл өөрийн дүгнэлтээ гаргаж шууд ХЭХ-д оруулж шийдвэр гаргуулна. Үүнээс өөрөөр томилогдсон гишүүнийг хууль бус томилгоотой гэж үзнэ.	НДХ
3	ТУЗ-ийн гишүүдийн томилгоо	Төр болон төрийг төлөөлсөн аливаа байгууллага түүний дотор толгой компани хараат бус гишүүний томилгоонд аливаа хэлбэрээр оролцох ёсгүй. Зөвхөн НДХ өөрийн болцоотой арга хэлбэрээ ашиглан сонгох ажиллагааг зохион байгуулах ба заавал нийтэд зарлан сонгох албагүй. Хамгийн гол нь компанийн хараат бус гишүүн ямар шаардлага хангасан хүн байх бодлого өмнө нь гарсан байх ёстой ба түүнийхээ дагуу хүнээ олж санал болгох	-
4	Хараат бус гишүүнд хаанаас санал болгосон	Төр болон төрийг төлөөлсөн аливаа байгууллага түүний дотор толгой компани хараат бус гишүүний томилгоонд аливаа хэлбэрээр оролцох ёсгүй. Зөвхөн НДХ өөрийн болцоотой арга хэлбэрээ ашиглан сонгох ажиллагааг зохион байгуулах ба заавал нийтэд зарлан сонгох албагүй. Хамгийн гол нь компанийн хараат бус гишүүн ямар шаардлага хангасан хүн байх бодлого өмнө нь гарсан байх ёстой ба түүнийхээ дагуу хүнээ олж санал болгох	ТУЗ-ийн НДХ
5	Хараат бус гишүүнд зохих шаардлага хангасан хүнийг томилсон байдал	Төр болон төрийг төлөөлсөн аливаа байгууллага түүний дотор толгой компани хараат бус гишүүний томилгоонд аливаа хэлбэрээр оролцох ёсгүй. Зөвхөн НДХ өөрийн болцоотой арга хэлбэрээ ашиглан сонгох ажиллагааг зохион байгуулах ба заавал нийтэд зарлан сонгох албагүй. Хамгийн гол нь компанийн хараат бус гишүүн ямар шаардлага хангасан хүн байх бодлого өмнө нь гарсан байх ёстой ба түүнийхээ дагуу хүнээ олж санал болгох	-
6	Хорооны бүрэлдэхүүний ажиллагаа зохих журмын дагуу явагддаг эсэх	НДХ нь өөрийн үйл ажиллагаа явуулах журмыг ТУЗ-өөр батлуулан ажиллах ёстой. Хорооны ажлыг жил бүр ТУЗ-өөс дүгнэлт өгч ажиллагааг нь удирдах.	ТУЗ-ийн НБД, ТУЗ-ийн НДХ

7	Хараат бус гишүүнд өгөх урамшуулал бусад гишүүдээс ялгаатай эсэх	Хараат бус гишүүн бусад гишүүнтэй адил эрх үүрэгтэй байхаас гадна КТХ-иар нэмэлт 5 үүрэгтэй байхаар заажээ. Иймд тэд бусад гишүүдээс илүү их зүйлд анхаарал тавьж ажиллах тул тэдэнд бусад гишүүдээс илүү цалин урамшуулал өгдөг байх. Энэ талаар ажиллах журамд нь заалт оруулах	ТУЗ
8	ТУЗ-ийн төрийг төлөөлж буй гишүүд хуралд хэлэлцэх асуудлаар санал өгөхдөө удирдамж авдаг эсэх	Төрийг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүд хуралд ирэхдээ өөрийг нь томилуулахаар санал гаргасан этгээдээс ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал бүрт санал өгөх удирдамжтай ирэх ёстой. Үүнийг ТУЗ-ийн дарга, НБД нар анхаарч ажиллах	ТУЗ-ийн дэргэдэх ЦУХ
9	Компанийн зүгээс ТУЗ-ийн гишүүдтэй ажиллах тэднийг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр тусгайлан хангах ажиллагаа	Компаниас ТУЗ-тэй ажиллах, тэднийг зөв шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдуулан мэдээллээр хангах, хамтарч ажиллах тусгай төлөвлөгөөтэй болж түүнийгээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. Энэ нь хурлаар хэлэлцэх асуудлаас гадуур өгөх мэдээллийг хэлж байгааг анхаарах	ТУЗ-ийн дарга, НБД
10	ТУЗ-ийн гишүүдийн ажлын хуваарилалт	ТУЗ-ийн гишүүдийн мэргэжил, чадвартай нь уялдуулан ТУЗ-ийн бүрэн эрхтэй холбоотой асуудлаар хуваарилалт хийх	ТУЗ-ийн дарга
11	ТУЗ-ийн гишүүдийн ажлын дүгнэлт	Зөвлөмжийн төгсгөлд байгаа ТУЗ-ийн гишүүдийн ажил дүгнэх жишээг үндэслэн өөрийн компанид тохирсон хүснэгт гарган гишүүдийн ажлыг дүгнэдэг болох	ТУЗ-ийн дарга
12	ТУЗ-ийн гишүүдийн шагнал урамшуулал тэдний ажлын гүйцэтгэлтэй уялдсан эсэх	Зөвлөмжийн төгсгөлд байгаа жишээнээс санаа авч ТУЗ-ийн гишүүдийн цалинг шинэчлэн тогтоох	ТУЗ ба НБД
13	Гишүүдийн цалин, шагнал нийтэд нээлттэй байгаа эсэх	ТУЗ-ийн гишүүдийн авч буй цалинг цахим хуудасдаа тавьдаг болох	“-
14	Гишүүд ажлын лавлагаа материал бүхий тусгайлан хавтастай эсэх	Гишүүдийг шаардлагатай материалыг агуулсан тусгай хавтастай болгон түүнийгээ байнга шинэчилж байх	“-
15	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа	ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааны талаар дүрэмдээ заалт оруулах	ТУЗ
16	Хороодын ажил дүгнэдэг эсэх	Хороодыг байгуулсны дараа үйл ажиллагааг тогтмол дүгнэдэг болох, энэ талаар хорооны ажиллах журамд тодорхой заалт оруулах	“-
17	Тодорхой асуудлаар түр болон байнгын ажиллагаатай хороо ажилладаг эсэх	Байнгын ажиллагаатай 3 хорооноос гадна шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн эрхлэх ажлын хүрээнд ажлын хэсэг, хороодыг байгуулан ажилладаг болох	ТУЗ
18	Хороодын гишүүнд ажилласны төлөө урамшуулал олгодог эсэх	Хорооны гишүүдэд ажлынх нь гүйцэтгэлтэй холбогдуулан нэмэгдэл олгодог болох	“-
19	ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө	Зөвлөмжийн төгсгөлд байгаа жишээг үндэслэн ТУЗ-ийн ажлыг жилээр төлөвлөдөг болох	“-

20	ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх	Зөвлөмжийн төгсгөлд байгаа жишээг үндэслэн ТУЗ-ийн ажлыг дүгнэдэг болох	ТУЗ
21	ТУЗ-ийн ажлын тайлагналт	ТУЗ нь компанийн үйл ажиллагааг дүгнүүлэхийн хамт өөрийн ажлыг жилд 1-ээс доошгүй удаа ХЭХ-д тусгайлан тайлагнаж ажлаа дүгнүүлдэг болох	-"
22	ТУЗ-ийн үйл ажиллагаанд дүгнэлт өгдөг эсэх	-"	-"
23	ТУЗ-ийн гишүүдэд хариуцлагын даатгал хийлгэдэг байдал	ТУЗ-ийн гишүүд гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээдэг болсонтой холбогдуулан тэднийг тодорхой түвшинд эрсдэл хийх бололцоог хангах үүднээс албан тушаалын хариуцлагын даатгал хийлгэдэг болох	Компани
24	Мэдээллийг ил тод, нээлттэй болгох ажиллагаа	ТУЗ-ийн НБД хороод, хяналтын бүтэц, ХЭ-ийн ажиллагааг идэвхтэй дэмжиж ажиллахаас гадна мэдээллийг ил тод, нээлттэй болгох ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах шаардлагатай.	ТУЗ-ийн НБД

### 3.4 ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Компанийн гүйцэтгэх удирдлага

*Компанийн гүйцэтгэх удирдлага (ГУ) нь ТУЗ-ийн шийдвэрээр томилогдон түүнд ажлаа тайлагнан дүгнүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх, үүрэг бүхий этгээд мөн.*

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох болон үйл ажиллагааг зохицуулсан тусгай журамтай эсэх	Төрийн өмч давамгайлсан компанийн хувьд төрийн нөлөө их байх тул ГЗ-ын үйл ажиллагааг тусгайлан журамлаж түүнийхээ дагуу ажилладаг болгох нь маш чухал. Ялангуяа нэр дэвшүүлэх, томилох ажиллагаа маш тодорхой байх. Энэ ажиллагаанд НДХ-ны үүргийг илүү тодорхой болгох	ТУЗ
2	Нэр дэвшүүлэх ажиллагаа	ГЗ-ын албан тушаалд нэр дэвшүүлэх ажиллагаа нь зөвхөн НДХ-ны хийх ажил болгох зарчмыг баримтлах	ТУЗ-ийн дэргэдэх НБХ
3	ГЗ-д компанийн онцлогтой уялдсан шаардлага тавьдаг эсэх	Компанийн тухайн үеийн онцлог байдалд уялдуулан ГЗ-ын албан тушаалд ажиллах хүнд тавих нөхцөл, шаардлагыг НДХ тогтоож түүндээ тохирсон хүнийг олж нэрийг нь дэвшүүлдэг байхаар ГЗ-ын ажиллах журамд зааж өгөх	-"
4	Үйл ажиллагаа болон гэрээний биелэлтийг тусд нь дүгнэдэг эсэх	ГЗ нь ТУЗ-тэй гэрээ байгуулж түүнийгээ жилд 2-оос доошгүй удаа дүгнүүлэн ажилладаг байх	ТУЗ
5	Ажлын тайлагналт улирал, жилээр		
6	Төрөөс ГЗ-тай шууд харьцдаг эсэх		
7	ГЗ-ын ажлыг ТУЗ-өөс өөр төрийн аль нэг байгууллага дүгнэдэг эсэх	ГЗ нь ТУЗ-өөс томилогдон түүнд ажлаа тайлагнах тул ХЭ түүний дотор том ХЭ болох төр шууд харьцах эсвэл үйл ажиллагааг дүгнэх бололцоогүй. Энд захиргааны байгууллагын хувьд төрийн харьцах харилцаа хамаарахгүй.	Төр
8	ГЗ-ын цалин, урамшуулыг нийтэд мэдээлдэг эсэх	Төрийн оролцоотой ХК-ийн хувьд ГЗ-ын цалин, урамшуулал нийтэд нээлттэй байх ёстой. Иймд энэ мэдээллийг жилийн тайланд тусган компанийн вэб дээр мэдээлж байх нь зүйтэй.	ТУЗ-ийн НБД



### 3.5 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Мэдээллийн ил тод, нээлттэй байдал

*ХЭ-ийн ээлжит хурал хуралдах үед компани ХЭ-дээ дараах мэдээллийг танилцуулах үүрэгтэй. Үүнд:*

- Санхүүгийн жилийн тайлан
- Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт
- Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал

Тус компани энэ бүлэгт хамаарах 55 асуулгын 22-т нь 0 оноотой гарчээ. Энэ дүнгээс харахад ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшүүлэх, хараат бус гишүүн сонгох, нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам боловсруулах зэргээр цаашид ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах зүйл нэлээдгүй байгааг доорх зөвлөмжийн хүрээнд тусган гаргалаа.

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Мэдээллийн бодлогын баримт бичигтэй эсэх	Үйл ажиллагааны нээлттэй байдал гэдэг бол КЗ-ын гол асуудлуудын нэг чухал хэсэг. Иймд Компани өөрийн онцлогт тохирсон мэдээллийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулж гаргах. Зөвлөмжийн төгсгөлд түүний бүтцийг харуулсан.	ТУЗ, ГЗ
2	Вэб хуудастай эсэх, түүнд КЗ-ын талаар тусгай булан байгаа эсэх КЗ-ын вэбийн хөтлөлт	Вэбд КЗ-ын тусгай хуудас нээж КЗ-ын холбоотой нээлттэй байх бүх мэдээлэлээ тавьж МИТНБМАЭ-ийн тухай хуульд заасны дагуу хөтлөх ба энэ асуудлаа МБББ-т дэлгэрэнгүй заасан байх	
3	Компани дээр болсон томоохон үйл явдлыг нийтэд тогтмол мэдээлдэг байдал	МБББ-т томоохон үйл ажиллагаа гэдгээ тодорхойлж энэ талаарх мэдээллийг вэб дээрээ байнга мэдээлж байх	-
4	Санхүүгийн мэдээллийг нийтэд мэдээлдэг эсэх, мөн мэдээллээ вэб дээр тогтмол байршуулдаг эсэх	Санхүүгийн мэдээллийг вэб дээр тогтмол мэдээлдэг журамтай болох	ТУЗ-ийн НБД

5	Худалдан авалтын ажиллагааны гүйцэтгэлийг нийтэд нээлттэй мэдээлдэг эсэх	Төрийн өмчийн оролцоотой ХК-ийн хувьд худалдан авалтын ажиллагаа нийтэд нээлттэй байх ёстой. Хамгийн гол нь худалдан авалт хийсэн этгээд, барааны нэр, үнэ зэргийг вэб дээрээ заавал мэдээлдэг байх ёстой. Иймд энэ талаар МБББ-т тусган хэрэгжүүлдэг болох.	“-
6	ТУЗ ба ГЗ-ын цалин, урамшууллыг жилийн тайланд тусгадаг эсэх	ТУЗ, ГЗ-ын цалин, урамшууллыг жилийн тайлан болон вэб дээрээ мэдээлдэг болох энэ талаар МБББ-ээ тусгах	“-
7	Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн жилийн нэгдсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт нийтэд зориулан тусгайлан эмхэтгэл болгон гаргадаг эсэх	Жил бүр компанийхаа санхүүгийн болон үйл ажиллагааг харуулсан эмхэтгэлийг нийтэд зориулан гаргадаг болох. Түүний бүтцийг зөвлөмжийн төгсгөлд үзүүлэв.	ТУЗ, ГЗ

### 3.6 ЧУХАЛ ХЭЛЦЭЛ ХИЙХ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Чухал хэлцэл

*Чухал хэлцэл гэдэгт компани дээр хийгдэж буй их хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, компанийн хяналтын багцыг авах зэрэг хэлцэл хамаарагдана. Эдгээр хэлцэл нь компанийн хөрөнгө, хувьцааны үнэ, хувьцаа эзэмшигчдийн эд хөрөнгийн эрх болон өмчлөлд томоохон нөлөө үзүүлдгээс гадна эдгээр хэлцлийг хийх үед ёс бус ажиллагаа нилээд гардаг. Энэ нь компанийн үйл ажиллагаанд томоохон эрсдэл, сөрөг үр дагавар үүсгэх тул засаглалын хүрээнд тусгайлан авч үздэг.*

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Их хэлцлийг нийтэд мэдээлдэг байдал	Их хэлцлийн тодорхойлолтыг компанийхаа онцлогт тохируулан тодорхойлж түүнийг хийх ажиллагааг тусд нь журамлах	ТУЗ, ГЗ
3	Жилийн тайланд тусгадаг байдал	Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэлцлийг тайлан болон вэб дээрээ тавьдаг болох	-
4	Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зохих журмын дагуу шийдсэн байдал	СЗХ хийх ажиллагааг тусгайлан журамлаж түүнийхээ дагуу ажиллах	ТУЗ-ийн НБД
5	Нийтэд мэдээлдэг байдал	Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их болон СЗХ-ийг тайлан болон вэб дээрээ тавьдаг болох	-
6	Жилийн тайланд тусгадаг байдал		
7	Эрх бүхий албан тушаалтан нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг өгсөн байдал	Компанийн дүрэмд заасан ЭБАТ-уудаас тэдний нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг авч компанийн вэб дээрээ тавьж сонирхогч талууд үзэх бололцоог хангасан байх	-
8	ЭБАТ болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэл нээлттэй байгаа эсэх		

### 3.7 НОГДОЛ АШГИЙН ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Ногдол ашиг

*Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчийн суурь эрхүүдийн нэг бөгөөд түүний эдийн засгийн агуулга нь оруулсан хөрөнгийнхөө өгөөжийг хүртэх хэлбэр юм. Компани санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор тухайн жилийн үр дүнгээс ногдол ашиг хуваах эсэх талаар шийдвэр гаргах ёстой.*

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Ногдол ашгийн бодлогын баримт бичиг байгаа эсэх	Ногдол ашгийг хуваарилах нөхцөл, журам, хуваарилсан бол түүнийг хэрхэн хувьцаа эзэмшигчид хүргэх, хүргэсэн тухай тайлан гаргах, хуваарилах эсэх зэрэг асуудлыг тусгасан бодлогын баримт бичигтэй байх нь зүйтэй бөгөөд энэхүү ББ-гээ нийтэд нээлттэй болгох	ТУЗ, ГЗ
2	Ногдол ашиг хуваарилсан байдал	ТУЗ-өөс Компанийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар заавал шийдвэр гаргадаг байх	--
3	Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт тусгах ёстой зүйлийг тусгасан байдал	Ногдол ашиг хуваарилах шийдвэрт хуульд заасан зүйлийг заавал тусгасан байх,	ТУЗ, ГЗ
4	Хуваарилсан ногдол ашгийг нябо бүртгэлд тусгаж буй байдал	Ногдол ашиг хуваарилах тохиолдолд хувьцаа эзэмшигч бүрээр өглөг болгон нябо бүртгэлд заавал бичилт хийдэг байх.	-- ТУЗ, ГЗ

### 3.8 ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Хяналтын тогтолцоо

*Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих нь удирдлагын маш чухал хэрэгсэл бөгөөд энэ нь өөрийн гэсэн эрх үүрэг бүхий дотоод гадаад бүтэцтэй бүхэл бүтэн систем тогтолцоо байдаг. Компанийн хяналтын тогтолцоо нь*

- Хяналтын зөвлөл
- Компанийн дотоод хяналт
- ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо
- Бие даасан хөндлөнгийн аудит зэргээс бүрэлдэнэ.

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Хөндлөнгийн аудитын тайланг нийтэд мэдээлдэг байдал	Аудитын өгсөн дүгнэлт бүхий санхүүгийн тайланг вэб дээрээ заавал тавьдаг байхаас гадна сонирхогч талууд үзэх бололцоог хангасан байх	ТУЗ, ГЗ
2	Дотоод хяналтын албаны ажиллагаа	Компанийн дотоод хяналтын албаны томилгоо, болон үйл ажиллагаа, ажлын тайлагналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны ажиллагаатай уялдуулах, энэ талаар аудитын хорооны ажиллах журамд тодорхой заалт оруулах	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо
3	Хорооны үйл ажиллагааны тайлагналт, дүгнэдэг байдал	Аудитын хорооны үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу явуулах үр дүнг жилд 4-өөс доошгүй удаа ТУЗ авч хэлэлцэж дүгнэлт өгдөг байх	ТУЗ

### 3.9 ДҮРЭМ БОЛОН БУСАД ЭРХИЙН АКТУУДЫН ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

#### Компанид засаглалын чиглэлээр байх дотоод эрхийн актууд

- Компанийн дүрэм
- Компанийн мэдээллийн бодлогын баримт бичиг
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам
- Нөгдол ашгийн бодлого
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Компанийн аюулгүй ажиллагааны бодлогын баримт бичиг
- Хяналтын зөвлөл/хянан шалгагчийн ажиллах журам
- Компанийн эрсдэлийн бодлогын баримт бичиг
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
- Компанийн хөдөлмөрийн дотоод журам
- Компанийн НБД-ын даргын ажиллах журам
- Компанийн засаглалын кодекс
- Дотоод хяналтын нэгжийн ажиллах журам
- Салбар нэгжийн ажиллах журам
- ТУЗ-ийн хороодын ажиллах журам
- Компанийн ёс зүйн дүрэм

№	Үнэлгээнд доогуур оноо авсан үзүүлэлт	Хийх ажлын талаар өгөх зөвлөмж	Хариуцан хэрэгжүүлэгч
1	Дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг баталсан байдал	Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд зөвхөн тухайн нэмэлт, өөрчлөлтийн дор баталсан тухай тэмдэглэлийг хийж байх	ТУЗ, ГЗ
2	Дүрэм нийтэд нээлттэй байгаа эсэх	Дүрэм бол нийтэд нээлттэй байх баримт бичиг тул түүнийг сонирхогч этгээд чөлөөтэй үзэх бололцоог хангасан байх үүднээс вэб дээр тавьсан байх	-“-
3	Засаглалтай холбоотой ажиллагааг зохицуулсан эрхийн актууд байгаа эсэх	Зөвлөмжийн төгсгөлд үзүүлсэн засаглалтай холбоотой баримт бичгүүдийг боловсруулж ТУЗ-өөс батлан хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр баримт бичгийг боловсруулахдаа зөвлөмжийн төгсгөлд байгаа тэдгээр баримт бичгийн бүтцийг харуулсан жишээнээс санаа авах	ТУЗ ба НБД

# 4

## ХАВСРАЛТУУД

### ХАВСРАЛТ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД АШИГЛАХ ЗАРИМ БАРИМТ БИЧГИЙН ЗАГВАР

#### 1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс санал авах хуудсын жишээ

.... Төлөөлөн удирдах зөвлөлийн 20.. оны ..... дүгээр тогтоолын хавсралт  
“.....” -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар

хувьцаа эзэмшигчдээс **САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .....

нэр .....

регистрийн дугаар .....

ХЭ-ийн бүртгэлийн дугаар .....

эзэмшиж буй хувьцааны төрөл .....

тоо.....

Хурал 20.. оны ..... дүгээр сарын .....-ны өдрийн ..... цагаас .....д болно.

Д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Таны өгөх санал
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны ажлын тайлан	...хангалттай гэж үзэх		+		Хангалтгүй гэж үзэх
2.	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт	Шийдвэрийн төслийг бичих	+			
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон хараат бус гишүүдийг сонгох – Ердийн гишүүн – Хараат бус гишүүн	1. А .Болд 2..... 7. Д. Сүрэн 8. 9.			+	Д.Галт
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн 20.. оны төсвийг батлах	Шийдвэрийн төслийг бичих	+			
5	Ногдол ашиг хуваарилаагүй тухай танилцуулга	Шийдвэр гарахгүй				

**Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр ..... дүгээр сарын ..... болно.**

Санал өгсөн хувьцаа эзэмшигчийн гарын үсэг .....

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга .....

гишүүд: .....

.....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан .....

.....

Ар талд нь энэхүү саналын хуудсыг бөглөх зааврыг бичих



## 2. ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх хүснэгт

Дараах хүснэгтэд дурдсан асуулт бүрт ТУЗ-ийн гишүүд өөрсдийн үнэлгээг дор дурдсан байдлаар өгнө.

- 1 - нэлээд сайжруулах шаардлагатай  
2 - сайжруулах шаардлагатай  
3 - дунд зэрэг  
4 - сайн  
5 - маш сан

Үнэлгээний хүснэгтэд ТУЗ-ийн гишүүдийн нэр бичихгүй.

Нэг. Ерөнхий үйл ажиллагаа ба бүрэн эрхийн хэрэгжилт						
№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Компани болон түүний ХЭ-ийн сонирхлыг хамгаалахад ТУЗ үйл ажиллагаагаа хангалттай чиглүүлж байсан уу?					
2	ТУЗ шийдвэр гаргахдаа бизнесийн өртгийг нэмэгдүүлэх болон ХЭ-ийн бусад сонирхлыг хангахад чиглэгдэж байсан уу? Та үүнийг яаж үзэж байна?					
3	ТУЗ-ийн бүрэн эрх амьдрал дээр ХЭХ болон ГУ-ын бүрэн эрхээс хэр ялгагдан зааглагдаж байсан бэ?					
4	Та ТУЗ-ийг өөрийн үүрэг роль, бүрэн эрх болон гол зорилтуудаа бүрэн хэмжээнд ойлгон ажиллаж байгаа гэж үзэж байна уу?					
5	ТУЗ бүтэн жилийн туршид гол зангилаа асуудлуудыг шийдэхдээ компанийн үнэт зүйл, алсын хараа, стратеги зорилтуудыг хэр мэдэж ойлгож байсан бэ?					
6	ТУЗ компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах болон түүний стратегийг тодорхойлох өөрийн үүргээ хэр үр ашигтай хэрэгжүүлж байна?					
7	ТУЗ компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тавих хяналтаа бололцоот хэрэгслүүд ашиглан хэрэгжүүлж чадаж байгаа юу?					
8	ТУЗ компанийн ГУ-ын ажлыг дүгнэх өөрийн үүргээ хэр сайн хэрэгжүүлж байгаа вэ?					

Тайлбар:

**Хоёр. ТУЗ-ийн гишүүд**

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Гишүүдийн тоо шаардлага хангаж байгаа юу? ТУЗ-ийн болон түүний хороодын удирдлага хэр үр ашигтай ажиллаж байна?					
3	ТУЗ-ийн гишүүдийн тоо тэдний мэдлэг, туршлага, чадвар болон бусад байх ёстой чанарын талаар боловсруулсан, хэрэгжүүлсэн, төлөвлөж буй бодлого байгаа юу?					
4	Компанийн стратегийг боловсруулах болон үйл ажиллагаанд шаардлагатай хяналтыг хэрэгжүүлэхэд одоогийн ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг, чадвар болон ТУЗ-ийн бүтэц хангалттай юу?					
5	ТУЗ-ийн гишүүдийн хамтын ажиллагаа хэр үр ашигтай вэ? Тухайлбал, ТУЗ хамтын байгууллагын хувьд хэр үр дүнтэй ажиллаж байна? Тодорхой чухал санал гаргасан гишүүнийг урамшуулдаг уу?					
6	ТУЗ-ийн хараат бус гишүүн бодит байдалд үнэхээр хараат бус байж чаддаг уу?					

Тайлбар:

**Гурав. ТУЗ-ийн хороод**

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	ТУЗ-ийн дэргэд шаардлагатай хороод ажилладаг уу?					
2	Хороод хэр үр ашигтай ажиллаж байна гэж үздэг вэ? Тэд шаардлагатай зөвлөмж өгч чаддаг уу?					
3	Хорооны гишүүд тухайн хорооныхоо хариуцсан чиглэлээр хангалттай мэдлэг чадвар, туршлагатай юу?					
4	Хорооны гишүүн бус ТУЗ-ийн гишүүд хорооны шийдвэрийн талаар мэдээлэл хэр авдаг вэ?					

Тайлбар:

**Дөрөв. ТУЗ-ийн үйл ажиллагаа**

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	ТУЗ чухал асуудлаа хэр зөв тодорхойлж чаддаг вэ? Ийм асуудлуудыг хэлэлцэх төлөвлөгөө график байдаг уу?					
2	Та ТУЗ-ийн хуралд сайн бэлтгэхийн тулд хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг хангалттай цаг хугацаанд урьдчилан авдаг уу?					
3	Дээрх мэдээллийг хурлаас өмнө агуулга чанарын хувьд авч чаддаг уу?					

4	ТУЗ-ийн хурал хэлэлцэж буй асуудлаар гишүүд хоорондоо нээлттэй саналаа солилцон хэлэлцэж цаг тухайд нь шийдвэрээ гаргаж чаддаг уу?					
5	ТУЗ-ийн хуралд асуудал танилцуулагч шийдвэр гарахад шаардлагатай мэдээлэл өгч чаддаг уу?					
6	Асуудал хэлэлцэх ба танилцуулах хугацааны хуваарилалт хэр зөв явагддаг вэ?					
7	ТУЗ-ийн хурлын зэрэгцээ компанийн албан хаагчидтай мэдээлэл солилцох бололцоо байдаг уу?					
8	ГУ-ын ажлыг дүгнэхийн тулд ТУЗ компанийн үр ашгийн үзүүлэлтийг тодорхойлдог уу?					
9	ТУЗ-ийн хурлын өмнө танд танилцуулсан санхүүгийн мэдээлэл нь компанийн чухал асуудал болон хэтийн чиглэлийг ойлгоход хангалттай мэдээлэл болдог уу?					
10	Танд өгч буй санхүүгийн мэдээллийн хэлбэр нь компанийн чухал асуудал ба хэтийн чиглэлийг салгасан байдаг уу?					
11	ТУЗ болон ГУ нь компанийн үйл ажиллагаанд гол нөлөө үзүүлэх эрсдэлд анхаарлаа төвлөрүүлж ажилладаг гэж хэлж чадах уу?					
12	ТУЗ-д эрсдэлийг хянах систем байгаа юу?					
13	Шинээр сонгогдсон гишүүдэд компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн ажиллах журмыг танилцуулах мэдээлэл бий юу?					

Тайлбар:

#### Тав. ТУЗ-ийн үүрэг, хариуцлага

№	Асуултууд	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Компанитай холбоотой асуудал үүсэхэд хүлээх үүргийн талаар мэдээлэл өгсөн үү, өгсөн бол хэр хангалттай байсан бэ?					
